

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны ... дугаар
сарын ... –ны өдөр

Улаанбаатар
хот

ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Зөрчлийн тухай хуульд доор дурдсан агуулгатай 15.29 дүгээр зүйл нэмсүгэй:

“15.29 дүгээр зүйл.Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль зөрчих

1.Гадаад улсын хуулийн зөвлөх Монгол Улсад хуулийн зөвлөх үйл ажиллагаа эрхлэх журмыг зөрчсөн бол хүнийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2.Хуульчийн мэргэжлийн нэрийг хэрэглэх эрхгүй хүн хуульчийн мэргэжлийн нэрийг ашигласан, хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа явуулсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гучин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

3.Хуулийн зөвлөхийн үйл ажиллагааны нууцыг хадгалах үүрэгтэй этгээд уг нууцыг хууль бусаар задруулсан, эсхүл хувийн болон гуравдагч этгээдийн ашиг сонирхлын тулд ашигласан бол хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

4.Хуулийн зөвлөхөөс мэргэжлийн үйл ажиллагаагаа эрхлэх эрхийг хязгаарласан буюу түүнээс хуулийн хүрээнд мэргэжлийн үйл ажиллагаагаа эрхлэхэд нь дарамт шахалт үзүүлсэн, саад учруулсан, баталгаа шаардсан, заналхийлсэн, эсхүл бусад байдлаар хөндлөнгөөс нөлөөлсөн бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны ... дугаар
сарын ... –ны өдөр

Улаанбаатар
хот

ХУУЛЬЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ

1 дүгээр зүйл. 2012 оны 3 дугаар сарын 07-ны өдөр батлагдсан Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн дагуу хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авч хуульчдын нэгдсэн бүртгэлд бүртгэгдсэн хуульчийн зөвшөөрөл нь Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль /шинэчилсэн найруулга/-д заасан зөвшөөрлийн нэгэн адил хүчинтэй байна.

2 дугаар зүйл. 2013 оны 2 дугаар сарын 8-ны өдөр батлагдсан Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 3 дугаар зүйлд зааснаар хуульчийн гэрчилгээ нь хүчингүй болсон хүн Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсноос хойш 180 хоногийн дотор хуульчдын нэгдсэн бүртгэлд бүртгэснээр Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль /шинэчилсэн найруулга/-д заасан “хуульч”-д тооцогдоно.

3 дугаар зүйл. Энэ хуулийн 2 дугаар зүйлд заасны дагуу бүртгэх журмыг Монголын Хуульчдын холбоо хууль тогтоомжид нийцүүлэн батална.

4 дүгээр зүйл. Энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан журмын дагуу хуульчдийн нэгдсэн бүртгэлд бүртгэхээс татгалзсан шийдвэрт Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 12 дугаар зүйлд заасан журмын дагуу гомдол гаргана.

5 дугаар зүйл. Хуульчдын холбооны Их хурлыг Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 90 хоногийн дотор хуралдуулна.

6 дугаар зүйл. Хуульчдын холбооны Их хурал 500 хүртэл хуульчийн төлөөлөлтэй байх бөгөөд төлөөлөгчдийг 2012 оны 3 дугаар сарын 7-ны өдөр батлагдсан Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 30 дугаар зүйлд заасан хуульчдын нэгдсэн бүртгэлд хамрагдсан хуульчдаас сонгон оролцуулах бөгөөд сонгох журмыг Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Монголын Хуульчдын холбоотой Ерөнхийлөгчтэй хамтран батална.

7 дугаар зүйл.Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн дагуу үүсгэн байгуулагдсан Монголын Хуульчдын холбоо нь 2012 оны 3 дугаар сарын 7-ны өдөр батлагдсан Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн дагуу байгуулагдсан Монголын Хуульчдын холбооны эрх залгамжлагч байна.

8 дугаар зүйл.Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 7.1, 8.1, 9.1-д заасан хуульчийн шалгалт зохион байгуулахтай холбоотой, мөн хуулийн 58 дугаар зүйлд заасан хууль зүйн сургуулийг магадлан итгэмжлэхтэй холбоотой зохицуулалтыг 2021 оны 7 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

9 дүгээр зүйл.2012 оны 3 дугаар сарын 7-ны өдөр батлагдсан Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн дагуу хангасан сургалтын багц цагийг үргэлжлүүлэн тооцно.

10 дугаар зүйл.Энэ хуулийг Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны ... дугаар
сарын ... –ны өдөр

Улаанбаатар
хот

ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Зөрчил, шалган шийдвэрлэх тухай хуулийн 18.8 дугаар зүйлийн 6.8 дахь заалтын “15.28 дугаар зүйлд” гэснийг “15.28, 15.29 дүгээр зүйлд” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны ... дугаар
сарын ... –ны өдөр

Улаанбаатар
хот

БОЛОВСРОЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Боловсролын тухай хуулийн 26 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 26.9 дэх хэсэг нэмсүгэй:

“26.9.Хууль зүйн дээд боловсролын сургалтын байгууллагыг Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд заасны дагуу Монголын Хуульчдын Холбоо магадлан итгэмжилнэ.”

2 дугаар зүйл.Боловсролын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсгийн “Боловсролын магадлан итгэмжлэлийг” гэснийг “Хуульд өөрөөр заагаагүй бол боловсролын магадлан итгэмжлэлийг” гэж, мөн зүйлийн 26.3 дахь хэсгийн “Магадлан итгэмжлэх” гэснийг “Хуульд өөрөөр заагаагүй бол магадлан итгэмжлэх” гэж, мөн зүйлийн 26.5 дахь хэсгийн “Боловсролын сургалтын байгууллагыг” гэснийг “Энэ хуулийн 26.9-д зааснаас бусад тохиолдолд боловсролын сургалтын байгууллагыг” гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Энэ хуулийг Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны ... дугаар
сарын ... –ны өдөр

Улаанбаатар
хот

ХУУЛЬЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 2012 оны 3 дугаар сарын 7-ны өдөр батлагдсан Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны ... дугаар
сарын ... –ны өдөр

Улаанбаатар
хот

ХУУЛЬЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 2013 оны 2 дугаар сарын 8-ны өдөр батлагдсан Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг